



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/189

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хэсэгчлэн шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 513 дугаар тогтоол, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газрын хүсэлтийг тус тус үндэслэн сумын Засаг даргын 2008 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн №99 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 14 дүгээр хэсэгт Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (9070656)-т эзэмшүүлсэн Мөрөн сумын 13 дугаар баг Баян-Эрхэт-1 107 тоотод байршилтай 6712008864 нэгж талбарын дугаар бүхий төрийн үйлчилгээний зориулалттай 17431м² газраас хувааж Хөвсгөл аймгийн мал эмнэлгийн газар (4142888)-т 6674м² газрыг хэсэгчлэн шилжүүлж, үлдсэн 10739 м² газрыг Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт үлдээн 25 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн №99 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 14 дэх хэсгийг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (9070656), Хөвсгөл аймгийн мал эмнэлгийн газар (4142888)-тай тус тус газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

671 1010050